



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

ЭРДЭНЭЦОГТ СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН 2020 ОНЫ САНХҮҮГИЙН  
ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

АУДИТЫН КОД: БНА-2021/151/СТА-ТШЗ

Баянхонгор 2021 он	Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат Утас: 99007576      Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn Хэлтсийн дарга бөгөөд аудитын менежер: А.Цээням Утас: 88011833      Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn “Баянташаагийн эх аудит” ХХК-ний аудитор: Ч.Чимгээ Утас: 89915909      Цахим хаяг: bte.audit@yahoo.com Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a>
-----------------------	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

**Агуулга**

1.Төрийн аудитын санал, дүгнэлт /Эх хувь/.....	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан .....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	7
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	8
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан .....	9
3.Аудитын тайлан .....	9
3.1. Ерөнхий зүйл .....	9
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй.....	10
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт.....	10
3.4. Материаллаг байдал.....	11
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд .....	11
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт.....	12
3.7. Шилэн дансны мэдээлэл.....	13
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	14
3.9. Аудитын илрүүлэлт .....	14
Залруулсан алдаа.....	14
Аудитын зөвлөмж .....	14
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд.....	14
4. Менежментийн захидал.....	15
5. Хавсралт Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт .....	16



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

64101 Баянхонгор аймаг,  
Баянхонгор сум, Номгон баг  
Утас, факс 7044 2584  
E-mail; bayankhongor@audit.gov.mn

Г БАЯНХОНГОР АЙМГИЙН  
ЭРДЭНЭЦОГТ СУМЫН ЭРҮҮЛ  
МЭНДИЙН ТӨВИЙН ЭРХЛЭГЧ С.БАТНЯМ  
ТАНАА 7

2021. 02.18 № 2146  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

Г **Аудитын гэрчилгээ** 7

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор аймгийн Эрдэнэцогт сумын Эрүүл мэндийн төвийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

**Зөрчилгүй санал дүгнэлт**

Баянхонгор аймгийн Эрдэнэцогт сумын Эрүүл мэндийн төвийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдлын тайлан, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

**Санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Баянхонгор аймгийн Эрдэнэцогт сумын Эрүүл мэндийн төвийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон

2021 А4 ТООТ

005020965

удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

### Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудитыг хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР Б.МӨНХБАТ



**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>72,140,932.35</b>	<b>82,935,087.71</b>
33	АВЛАГА	5,015.00	37,050.70
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	5,015.00	37,050.70
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>72,135,917.35</b>	<b>82,898,037.01</b>
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	<b>29,519,137.00</b>	<b>35,072,551.00</b>
35110	Тусгай зориулалттай материал	28,526,249.00	28,526,249.00
35130	Эм боох материал	992,888.00	6,546,302.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>38,784,280.35</b>	<b>43,992,986.01</b>
35410	Бичиг хэргийн материал	1,503,910.00	699,400.00
35420	Аж ахуйн материал	33,576,394.01	36,743,683.01
35430	Сэлбэг хэрэгсэл	00.00	66,000.00
35440	Тулш, шатах тослох материал	00.00	800,000.00
35450	Барилгын засварын материал	1,026,500.00	1,026,500.00
35460	Хүнсний материал	1,574,976.34	486,903.00
35470	Бусад хангамжийн материал	1,102,500.00	4,170,500.00
35600	Мал амьтад	3,832,500.00	3,832,500.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>385,543,878.99</b>	<b>401,237,038.12</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>385,543,878.99</b>	<b>401,237,038.12</b>
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>377,407,878.99</b>	<b>393,101,038.12</b>
39201	Барилга, байгууламж, орон сууц	344,642,898.29	344,642,898.29
39202	Хуримтлагдсан элэгдэл	-19,796,979.48	-34,601,158.92
39203	Авто-тээврийн хэрэгсэл	38,736,434.00	70,236,434.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-15,312,144.72	-24,693,217.08
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	84,175,049.00	100,393,977.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-59,227,129.20	-67,019,283.48
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	9,259,841.00	9,259,841.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-5,070,089.90	-5,118,452.69
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>8,136,000.00</b>	<b>8,136,000.00</b>
39303	Бусад биет бус хөрөнгө	8,136,000.00	8,136,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>457,684,811.34</b>	<b>484,172,125.83</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>00.00</b>	<b>15,569,389.30</b>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	00.00	15,569,389.30
413	Өглөг	00.00	15,569,389.30
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	00.00	1,898,878.20
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	00.00	12,733,011.10
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	<b>00.00</b>	<b>937,500.00</b>
41361	Байгууллагад төлөх өглөг	00.00	937,500.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>457,684,811.34</b>	<b>468,602,736.53</b>
51	Засгийн газрын хувь оролцоо	457,684,811.34	468,602,736.53
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	259,003,817.00	259,003,817.00
51101	Өмч: - төрийн	259,003,817.00	259,003,817.00
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>-108,925,580.00</b>	<b>-98,007,654.81</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	-108,925,580.00	-108,925,580.00
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	10,917,925.19
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	307,606,574.34	307,606,574.34
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>457,684,811.34</b>	<b>484,172,125.83</b>

**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан**

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>435,665,400.00</b>	<b>519,646,581.20</b>
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>00.00</b>	<b>49,586,845.20</b>
120	Нийтлэг татварын бус орлого	00.00	49,586,845.20
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	00.00	49,586,845.20
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	00.00	49,586,845.20
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>435,665,400.00</b>	<b>470,059,736.00</b>
1310	Удсын төвлөрсөн төсвөөс	367,964,000.00	371,902,500.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	367,964,000.00	371,902,500.00
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>111,100.00</b>	<b>24,007,936.00</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	111,100.00	17,987,436.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	00.00	6,020,500.00
1320	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>36,641,500.00</b>	<b>31,930,900.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	36,641,500.00	31,930,900.00
1340	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	<b>30,948,800.00</b>	<b>42,218,400.00</b>
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	30,948,800.00	42,218,400.00
2	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>453,883,489.00</b>	<b>508,728,656.01</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>453,883,489.00</b>	<b>508,728,656.01</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>452,446,226.00</b>	<b>479,945,418.00</b>
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>268,444,171.80</b>	<b>298,569,614.00</b>
210101	Үндсэн цалин	268,435,869.00	214,872,562.21
210102	Нэмэгдэл	00.00	62,411,734.63
210104	Урамшуулал	00.00	21,285,317.16
210105	Гэрээт ажлын хөлс	8,302.80	00.00
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>33,551,355.00</b>	<b>38,046,694.50</b>
210201	Тэтгэрийн даатгал	33,551,355.00	26,148,435.55
210202	Тэтгэмжийн даатгал	00.00	3,248,487.30
210203	ҮОМШӨ-ний даатгал	00.00	2,411,404.84
210204	Ажилгүйдлийн даатгал	00.00	567,139.89
210205	Эрүүл мэндийн даатгал	00.00	5,671,226.92
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>32,312,005.00</b>	<b>28,945,051.00</b>
210301	Гэрэл, шахилгаан	2,393,473.00	2,089,651.00
210302	Түши, халаалт	29,821,732.00	26,749,800.00
210303	Цэвэр, бохир ус	96,800.00	105,600.00
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>26,664,184.00</b>	<b>25,115,148.00</b>
210401	Бичиг хэрэг	2,199,240.00	2,235,960.00
210402	Тээвэр, шатахуун	19,943,464.00	18,685,600.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,342,080.00	2,044,988.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	529,400.00	1,785,100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	00.00	363,500.00
210408	Бараа материал акталсны зардал	1,650,000.00	00.00
2105	<b>Нормативт зардал</b>	<b>36,545,250.86</b>	<b>39,028,176.64</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	30,449,902.20	33,946,575.30
210502	Хоол, хүнс	4,942,103.66	5,081,601.34
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,153,245.00	00.00
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>1,856,396.00</b>	<b>2,925,000.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	22,000.00	1,450,000.00
210604	Урсгал засвар	1,834,396.00	1,475,000.00
2107	<b>Томилголт, зочны зардал</b>	<b>752,000.00</b>	<b>1,439,400.00</b>
210702	Дотоод албан томилголт	752,000.00	1,439,400.00
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>720,260.00</b>	<b>38,800.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	322,100.00	38,800.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	344,300.00	00.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	53,860.00	00.00
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>51,600,603.34</b>	<b>45,837,533.87</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	19,135,290.00	13,811,765.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорголдол	32,465,313.34	32,025,768.87
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>1,437,263.00</b>	<b>28,783,238.00</b>
2132	Бусад урсгал шилжүүлэг	00.00	16,149,636.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	00.00	16,149,636.00
2134	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>1,329,599.00</b>	<b>2,726,349.00</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,329,599.00	1,385,849.00
213404	Хөрөнгийн	00.00	1,340,500.00
2135	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>107,664.00</b>	<b>9,907,253.00</b>
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	107,664.00	9,907,253.00
3	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>-18,218,089.00</b>	<b>10,917,925.19</b>
225	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>396,607.70</b>	<b>00.00</b>
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	396,607.70	00.00
4	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	<b>-396,607.70</b>	<b>00.00</b>
5	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>-18,614,696.70</b>	<b>10,917,925.19</b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>435,665,400.00</b>	<b>470,059,736.00</b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>435,665,400.00</b>	<b>470,059,736.00</b>
131007	Тусгай зориулалтын шилжүүлтгээс санхүүжих	367,964,000.00	371,902,500.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>111,100.00</b>	<b>24,007,936.00</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	111,100.00	17,987,436.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	00.00	6,020,500.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>36,641,500.00</b>	<b>31,930,900.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	36,641,500.00	31,930,900.00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	<b>30,948,800.00</b>	<b>42,218,400.00</b>
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	30,948,800.00	42,218,400.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>435,665,400.00</b>	<b>456,810,736.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>435,665,400.00</b>	<b>456,810,736.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>434,228,137.00</b>	<b>428,014,098.00</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>268,430,169.00</b>	<b>296,554,522.00</b>
210101	Үндсэн цалин	199,615,500.00	212,857,470.21
210102	Нэмэгдэл	53,359,784.00	62,411,734.63
210104	Урамшуулал	15,454,885.00	21,285,317.16
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>33,557,300.00</b>	<b>38,194,944.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	22,298,900.00	26,547,100.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,814,600.00	2,965,900.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,251,700.00	2,372,600.00
210204	Ажилгүйдлийн даатгал	562,900.00	534,008.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5,629,200.00	5,775,336.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>32,312,005.00</b>	<b>28,945,051.00</b>
210301	Гэрэл, нахилгаан	2,722,705.00	2,089,651.00
210302	Тули, халаалт	29,492,500.00	26,749,800.00
210303	Цэвэр, бохир ус	96,800.00	105,600.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>20,894,924.00</b>	<b>24,311,688.00</b>
210401	Бичиг хэрэг	1,199,260.00	1,430,488.00
210402	Тээвэр, шатахуун	16,531,214.00	18,400,400.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,016,000.00	2,024,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,148,450.00	1,997,400.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ажуйн эд зүйлс	00.00	459,400.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>36,136,613.00</b>	<b>17,137,928.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	31,362,113.00	10,719,400.00
210502	Хоол, хүнс	4,202,600.00	3,993,528.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	571,900.00	2,425,000.00
<b>2106</b>	<b>Эд хөгшил, урсгал засварын зардал</b>	<b>6,904,896.00</b>	<b>3,660,000.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,505,000.00	2,060,000.00
210602	Тавилга	1,400,000.00	00.00
210604	Урсгал засвар	2,999,896.00	1,600,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>752,000.00</b>	<b>1,439,400.00</b>
210702	Дотоод албан томилолт	752,000.00	1,439,400.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>509,260.00</b>	<b>1,605,400.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	111,100.00	1,205,400.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	398,160.00	400,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>34,730,970.00</b>	<b>16,165,165.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	34,730,970.00	16,165,165.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>1,437,263.00</b>	<b>28,796,638.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>00.00</b>	<b>16,163,036.00</b>
213208	Хөлөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлдэх дэмжлэг	00.00	16,163,036.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>1,329,599.00</b>	<b>2,726,349.00</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,329,599.00	1,385,849.00
213404	Хөрөнгийн	00.00	1,340,500.00
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>107,664.00</b>	<b>9,907,253.00</b>
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	107,664.00	9,907,253.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>00.00</b>	<b>13,249,000.00</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>00.00</b>	<b>13,249,000.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>00.00</b>	<b>13,249,000.00</b>
2200	Дотоод эх үүсвэрээр	00.00	13,249,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	00.00	13,249,000.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>00.00</b>	<b>-13,249,000.00</b>
<b>7</b>	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>
<b>9</b>	<b>Мөнгө, түүнгэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>
<b>10</b>	<b>Мөнгө, түүнгэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нооц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C08	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	259,003,817.00	307,606,574.34	-108,925,580.00	00.00	457,684,811.34
D01	2020 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	259,003,817.00	307,606,574.34	-108,925,580.00	00.00	457,684,811.34
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	259,003,817.00	307,606,574.34	-108,925,580.00	00.00	457,684,811.34
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	10,917,925.19	00.00	10,917,925.19
D09	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	259,003,817.00	307,606,574.34	-98,007,654.81	00.00	468,602,735.53

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Дүн	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	446,393,800.00	434,758,698.00	11,635,102.00	97.39853
21	УРСГАЛ ЗАРДАЛ	446,393,800.00	434,758,698.00	11,635,102.00	97.39853
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	446,393,800.00	434,758,698.00	11,635,102.00	97.39853
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	296,559,400.00	296,554,522.00	4,878.00	99.99836
210101	Үндсэн цалин	212,860,900.00	212,857,470.21	3,429.79	99.99839
210102	Нэмэгдэл	62,412,400.00	62,411,734.63	665.37	99.99893
210104	Урамшуулал	21,286,100.00	21,285,317.16	782.84	99.99632
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	38,409,500.00	38,194,944.00	214,556.00	99.4414
210201	Тэтгэврийн даатгал	26,547,100.00	26,547,100.00	0.00	100
210202	Тэтгэмжийн даатгал	2,965,600.00	2,965,900.00	-300.00	100.0101
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,372,500.00	2,372,600.00	-100.00	100.0042
210204	Ажилгүйдлийн даатгал	593,100.00	534,008.00	59,092.00	90.03676
210205	Эрүүл мэндийн даатгал	5,931,200.00	5,775,336.00	155,864.00	97.37213
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	30,664,300.00	28,945,051.00	1,719,249.00	94.39832
210301	Гэрэл, цахилгаан	2,427,100.00	2,089,651.00	337,449.00	86.09662
210302	Түлш, халаалт	27,837,200.00	26,749,800.00	1,087,400.00	96.09872
210303	Цэвэр, бохир ус	400,000.00	105,600.00	294,400.00	26.4
2104	Хангамж, бараа материалын зардал	24,566,600.00	24,311,688.00	254,912.00	98.96236
210401	Бичиг хэрэг	1,431,000.00	1,430,488.00	512.00	99.96422
210402	Тээвэр, шатахуун	18,400,600.00	18,400,400.00	200.00	99.99891
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,112,000.00	2,024,000.00	88,000.00	95.83833
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,000,000.00	1,997,400.00	2,600.00	99.87
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	623,000.00	459,400.00	163,600.00	73.73997
2105	Нормативт зардал	26,818,500.00	17,137,928.00	9,680,572.00	63.90838
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	19,208,500.00	10,719,400.00	8,489,100.00	55.8055
210502	Хоол, хүнс	5,100,000.00	3,993,528.00	1,106,472.00	78.30447
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,510,000.00	2,425,000.00	85,000.00	96.61855
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	9,826,600.00	10,160,000.00	-333,400.00	103.3928
210601	Багаж, техник, хэрэгсэл	8,560,000.00	8,560,000.00	0.00	100
210604	Урсгал засвар	1,266,600.00	1,600,000.00	-333,400.00	126.3224
2107	Томилголт, зочны зардал	1,457,200.00	1,439,400.00	17,800.00	98.77848
210702	Дотоод албан томилолт	1,457,200.00	1,439,400.00	17,800.00	98.77848
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	400,000.00	400,000.00	0.00	100
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	400,000.00	400,000.00	0.00	100
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	17691700.00	17615165.00	76,535.00	99.5674
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	17,691,700.00	17,615,165.00	76,535.00	99.5674
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	0.00	0.00	0.00	0
2132	Бусад урсгал шилжүүлэг	00.00	00.00	0.00	0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.00	00.00	0.00	0

**Эрдэнэцогт сумын Эрүүл мэндийн төвийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зорүү	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Дүн	Хувь
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	446,393,800.00	434,758,698.00	11,635,102.00	97.39353
1310	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	371,902,500.00	361,995,247.00	9,907,253.00	97.33606
131007	Тусгай зориулалтын шилжүүлэгэс санхүүжих	371,902,500.00	361,995,247.00	9,907,253.00	97.33606
1320	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	31,930,900.00	30,545,051.00	1,385,849.00	95.65985
132001	Орон нутгийн төсвөөс	31,930,900.00	30,545,051.00	1,385,849.00	95.65985
1340	<b>НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	42,560,400.00	42,218,400.00	342,000.00	99.19644
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	42,560,400.00	42,218,400.00	342,000.00	99.19644
61	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	01.00	01.00	0.00	100
610001	Төсвийн байгууллага	01.00	01.00	0.00	100
62	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	26.00	26.00	0.00	100
620001	Удирдах ажилтан	01.00	01.00	0.00	100
620002	Гүйцэтгэх ажилтан	20.00	20.00	0.00	100
620003	Үйлчлэх ажилтан	05.00	05.00	0.00	100
64	<b>ЭМЧЛҮҮЛЭГСЭДИЙН ТОО</b>	334.00	334.00	0.00	100
640001	Улсын эмнэлгээр хэвтэн эмчлүүлэгсдийн тоо	334.00	334.00	0.00	100
65	<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	26.00	26.00	0.00	100
650008	Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ)	20.00	20.00	0.00	100
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	06.00	06.00	0.00	100

## 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>		<b>24,007,936.00</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>		<b>24,007,936.00</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>		22,667,436.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		6,517,800.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		6,517,800.00
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	0.00	17,490,136.00
2132	Бусад урсгал шилжүүлэг		16,149,636.00
213209	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлсэн дэмжлэг		16,149,636.00
213403	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг		1,340,500.00
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	0.00	<b>24,007,936.00</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		17,987,436.00
131105	Эрүүл мэндийн даатгалын санхүүжилт		6,020,500.00
<b>IV</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)-(II)-(I)</b>		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	0.00

## 3. Аудитын тайлан

### 3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Эрдэнэцогт сумын Эрүүл мэндийн төв 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг Эрүүл мэндийн төвийн дарга С.Батням танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл,

анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд төсвийн хөрөнгийн бүрдүүлэлт, зарцуулалтад тавих хяналтыг сайжруулах, үр ашигтай зарцуулах талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 01 дүгээр сарын 27-ээс 2021 оны 02 дугаар сарын 18-ны хооронд Баянташаагийн эх Аудит ХХК-ийн аудитор Ч.Чимгээ хариуцаж хэрэгжүүлэв.

Тус Эрүүл мэндийн төв нь 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийх хүсэлтийг Төрийн Аудитын газарт мөн оны 11 дугаар сарын 02-ны өдрийн 48 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

### **3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй**

Эрдэнэцогт сумын Эрүүл мэндийн төв нь алсын хараа, эрхэм зорилгоо хүн ардынхаа эрүүл мэндийг сайжруулахад үйлчлүүлэгчдээ “хамгийн ээлтэй тусламж үзүүлэгч” эрүүл мэндийн байгууллагаар үнэлэгдэж, итгэл хүлээлгэхийг эрмэлзэнэ, сумынхаа хүн амд эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг тасралтгүй зарчмаар стандартын дагуу чанартай тэгш, шударга жигд үзүүлэхээр тодорхойлжээ. Үүнд:

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт гараагүй байна. Дараах хууль тогтоомжийг мөрдөж байна.

- Төрийн аудитын тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
  - Шилэн дансны тухай хууль
  - Монгол Улсын 2020 оны Төсвийн тухай хууль
  - Татварын багц хуулиуд
  - Нийгмийн даатгалын тухай хууль
  - Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай
  - Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль

### **3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт**

Эрдэнэцогт сумын Эрүүл мэндийн төвийн санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Баянхонгор аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба 2020 онд харьяа орон нутаг дахь Эрдэнэцогт сумын Эрүүл мэндийн төвийн санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгээгүй байна.

Тус байгууллагын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд "Дунд" гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

### 3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшнийг "Дунд" гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 2019 оны жилийн эцсийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 454280,1 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 9085,6 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд 2020 оны жилийн эцсийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 508728,6 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 10174.6 мянган төгрөгөөр тооцов.

Санхүүгийн тайлангаар тусгай зориулалттай бараа материал дансанд 20035,5 мянган төгрөгийн, аж ахуйн материал дансанд 7397,9 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө бүртгэгдсэн байсныг ашигласан жилээр ангилж, зөрчилд тооцсныг материаллаг бус алдаанд тооцов.

### 3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Эрдэнэцогт сумын Эрүүл мэндийн төв 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх гол үзүүлэлтүүдийг өмнөх онтой зэрэгцүүлэн судлахад өмнөх оноос бараа материал, үндсэн хөрөнгийн данс нэмэгдсэн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт мян.төгрөгөөр

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	72,140.9	82,935.1	10,794.2
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	5.0	37.1	32.0
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	72,135.9	82,898.0	10,762.1
<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	385,543.9	401,237.0	15,693.2
Үндсэн хөрөнгө	484,950.2	532,669.2	47,718.9
Хуримтлагдсан элэгдэл	(99,406.3)	(131,432.1)	(32,025.8)
<b>Нийт хөрөнгө</b>	457,684.8	484,172.1	26,487.3
Өр төлбөр	-	15,569.4	15,569.4
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	457,684.8	468,602.7	10,917.9
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	457,684.8	484,172.1	26,487.3

Эх сурвалж: Тус байгууллагын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан

Тайлант онд бараа материалын дансны үлдэгдэл 82898,0 мянган төгрөг болж 10762,1 мянган төгрөгөөр өссөн нь эм боох материалын үлдэгдэл 5553,4 мянган, хангамжийн материал 5208,6 мянган төгрөгөөр өссөнөөс голлон шалтгаалсан. Энэ нь цар тахлаас урьдчилан сэргийлэх зорилгоор эм боох материалын болон шатахууны нөөц бүрдүүлсэнтэй холбоотой байна.

Аймгийн Эрүүл мэндийн газраас 10711,4 мянган төгрөгийн тендерийн эм, боох материал авснаас 7826,6 мянган төгрөгийг эмнэлэгт зарцуулж, эмнэлгийн эмийн эргэлтийн санд 2884,8 мянган төгрөгийн эм, боох материалын үлдэгдэлтэй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 532669,2 мянган төгрөг болж 47718,9 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь Эрүүл мэндийн Яамны хөрөнгө оруулалтаар 31500,0 мянган төгрөгийн автомашин, төсвийн хөрөнгөөр 13249,0 мянган төгрөгийн иммунологийн аппарат, хүчилтөрөгчийн аппарат, шээсний аппарат зэргийн худалдан авснаас голлон шалтгаалсан.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 468602,7 мянган төгрөг болж 10917,9 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн өссөнөөс шалтгаалжээ.

Тус байгууллагын санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого 519646,6 мянган төгрөг болж, өмнөх оноос 83981,2 мянган төгрөгөөр буюу 19,3 хувиар өссөн байна.

Өмнөх оноос тусламж санхүүжилтийн орлого 30455,8 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилт 3938,5 мянган, орон нутгийн төсвөөс олгосон санхүүжилт 4710,6 мянган, эрүүл мэндийн даатгалын сангийн санхүүжилт 11269,6 мянган төгрөгөөр тус тус нэмэгдсэнтэй холбоотой байна.

Нийт зардал 508728,6 мянган төгрөг байгаа нь өмнөх оноос 54845,1 мянган төгрөгөөр буюу 12,0 хувиар өссөн байна. Цалин, хөлс болон нэмэгдэл урамшлын зардал 30125,4 мянган, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал 4495,3 мянган, норматив зардал 2482,9,0 мянган төгрөгөөр тус тус нэмэгдэж, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 3367,0 мянган, хангамж бараа материалын зардал 1549,1 мянган, бараа үйлчилгээний бусад зардал 5763,1 мянган төгрөгөөр тус тус буурсантай холбоотой байна

### **3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 455269.8 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 455269,8 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 4376,0 мянган төгрөгөөр бууруулж 450902,8 төгрөгөөр анх баталсныг 1 удаа тодотгол хийж, 446393,8 мянган төгрөгөөр баталсан байна.

#### **Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр 446393,8 мянган төгрөгийн төсөв баталснаас 371902,5 мянган төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилтээр, 31930,9 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 42560,4 мянган төгрөгийг эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Төсвийн гүйцэтгэлээр тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилтээс 361995,3 мянган, орон нутгийн төсвөөс 30545,0 мянган, эрүүл мэндийн даатгалын сангаас 42218,4 мянган төгрөгийн санхүүжилт авч, нийт 434795,7 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагааны зардалд зарцуулсан байна.

**Эрдэнэцогт сумын Эрүүл мэндийн төвийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

Батлагдсан төсвөөс 11598,1 мянган төгрөг дутуу зарцуулсан нь байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 1719,3 мянган, хангамж бараа материалын зардлыг 254,9 мянган, нормативт зардлыг 9680,6 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

Нийт төсвийн зардлын гүйцэтгэлийг дутуу зарцуулсан нь 71602 хөтөлбөрийн 80109 арга хэмжээний зардал 1385,9 мянган, 80302 арга хэмжээний зардал 76,5 мянган, 81603 арга хэмжээний зардал 10135,7 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулагдснаас шалтгаалжээ.

**Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний зардлын гүйцэтгэл /мянган.төгрөгөөр/**

Д/Д	Хөтөлбөр, арга хэмжээний		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
	Код	Нэр				
1	71808	Эмнэлгийн тусламж, үйлчилгээ	446,393,8	434,795,7	(11,598,1)	97,3
1.1	81603	Үндсэн мэргэжлийн тусламж, үйлчилгээ	387,811,2	377,675,5	(10,135,7)	97,4
1.2	80109	Байр ашиглалтын үйлчилгээ	31,930,9	30545,1	(1385,8)	95,7
1.3	80302	Нэг хүнд ноогдох нормативт зардал	26,651,7	26,575,2	(76,5)	99,7

Эх сурвалж: Тус байгууллагын 2020 оны төсвийн хэлбэлзлийн тайлан

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

**Нэмэлт санхүүжилт**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтээр 24007,9 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлснээс хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлсэн дэмжлэг 16149,6 мянган төгрөгийг 4 ажиллагсдад олгож, 3500,0 мянган төгрөгийн Монбиофарм ХХК-д шээсний аппаратын үлдэгдэл, 1554,4,0 мянган төгрөгийг Сакура Медика ХХК-д хамгаалах хэрэгслийн үнэ, 1450,0 мянган төгрөгийг Ашид буян ХХК-д хүчилтөрөгч өтгөрүүлэгч аппаратын үнэ, 13,4 мянган төгрөгийг сорьц тээвэрлэлтийн зардалд төлж, 1340,5 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн байна.

**3.7. Шилэн дансны мэдээлэл**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 27 төрлийн 149 мэдээллийг хугацаанд бүрэн байршуулсан байна.

**Хүснэгт 3. Шилэн дансны мэдээлэл**

Д/д	Хугацаа	Төрөл	Удаа	Хугацаанд нь оруулсан	Хугацаа хоцроосон	Хугацаа болоогүй
1	Бүтэн жил	11	11	9		2
2	Хагас жил	4	4	4		
3	Улирал бүр	1	4	4		
4	Сар бүр	3	36	36		
5	Тухай бүр	8	96	96		
	Нийт	27	151	149		2

Эх сурвалж: www.shilendans.gov.mn цахим хуудас

### 3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажилласан байна.

### 3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 10026,4 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 9504,2 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага, 522,8 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоов.

#### Залруулсан алдаа

Санхүүгийн тайлангаар залруулсан алдаа байхгүй.

#### Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг менежментийн захидалд тусгаж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа зөрчилтэй асуудлыг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд :

##### 1. Балансын данстай холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт: Тусгай зориулалттай бараа материал дансанд 20035,5 мянган төгрөгийн, аж ахуйн материал дансанд 7397,9 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө бүртгэгдээд 3-7 жил болсон байна. Хөрөнгүүдийг цаашид ашиглах жилээр ангилахад 17929,2 мянган төгрөгийн эмнэлгийн зориулалттай тоног төхөөрөмжийн элэгдлийн хугацаа дууссан, 9504,2 мянган төгрөгийн тавилга, эд хогшил бүртгэгдсэн байгаад байгууллагын өмч хамгаалах зөвлөл хяналт тавьж ажиллаагүй байна.

Энэ нь "үнэн зөв байх", "оршин байх" батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар батлагдсан Нягтлан бодох бүртгэлийн дансны зааврын 4.30 -т Үндсэн хөрөнгийн "Хүлээн зөвшөөрөлт" хэсгийн "Үндсэн хөрөнгийн зүйлийг дараах тохиолдолд хөрөнгө хэмээн хүлээн зөвшөөрнө; хөрөнгөнд холбогдох эдийн засгийн ирээдүйн өгөөж буюу үйлчилгээний чадавхыг тухайн байгууллага хүртэх магадлалтай ба; хөрөнгийн өртөг эсвэл бодит үнэ цэнийг найдвартай үнэлэх боломжтой." гэсэн заалтыг тус тус зөрчсөн.

Шийдвэрлэсэн нь: Зөрчил арилгуулах тухай албан шаардлага өгөх

##### 2. Зардлын данстай холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт: Тухайн байгууллагын ажилтан Б.Дуламсүрэн, Б.Мөнхцэцэг, Д.Гэрэл нарын 2020 оны 2-р улирлын үр дүнгийн урамшууллын нийт 522180 төгрөгийн цалинд ноогдох 125323 төгрөгийн шимтгэлийг нийгмийн даатгалд мэдээлэлгүй өглөгөөр бүртгэсэн байна.

Энэ нь "эрх ба үүрэг" батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Нийгмийн даатгалын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д "Энэ хуулийн 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан даатгуулагчийн болон ажил олгогчийн тухайн сард төлбөл зохих нийгмийн даатгалын шимтгэлийг нийгмийн даатгалын төрөл бүрээр энэ хуулийн 15 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан хувь хэмжээгээр сар бүр тооцож, тухайн сард нь багтаан нийгмийн даатгалын сангийн дансанд шилжүүлнэ" гэсэн заалтыг тус тус зөрчсөн.

Шийдвэрлэсэн нь: Зөрчил арилгуулах тухай төлбөрийн акт тогтоох

Дээрх акт, албан шаардлагын биелэлтийг 2021 оны 5 сарын 15-ны дотор ирүүлэх

#### Аудитын зөвлөмж

Тайлант оны санхүүгийн тайлангаар нийт 15569,4 мянган төгрөгийн өглөгтэй байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй зөрчилд зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

### 3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Аймгийн хэмжээнд нэгдсэн журмаар эмийн тендерийн асуудлыг аймгийн ЭМГ нь зохион байгуулж, үнэгүй эм болон хамгаалах хэрэгсэл олгож байгаатай холбогдуулан эмийн ханган нийлүүлэлтийн асуудлыг дараагийн аудитаар авч үзэх шаардлагатай. Сумын эргэлтийн эмийн санд оны эцэст 2884,8 мянган төгрөгийн эм хадгалагдаж байна.

## 4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

### 1. Төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэхтэй холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт: Тайлант хугацааны санхүүгийн тайлангаар нийт 15569,4 мянган төгрөгийн өглөгтэй байгаа Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх.” заалтыг зөрчсөн.

1.2. Эрсдэл: Төсвийн үр ашиг буурч, зарлага нэмэгдэх

1.3 Өгсөн зөвлөмж: Төсвийг зохистой удирдаж Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.6.а-д “тодорхой төсөл, хөтөлбөр, арга хэмжээний зарлагыг нэмэгдүүлэхээр бол бусад төсөл, хөтөлбөр, арга хэмжээний зардлыг мөн хэмжээгээр бууруулж, нийт зарлагын хэмжээг нэмэгдүүлэхгүй байх” гэсэн заалтыг мөрдөж ажиллан ЭМДС-аас авах санхүүжилтийг хугацаанд нь авч өр авлагыг барагдуулж ажиллах.

1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан тухайн удирдлага нарт талархал илэрхийлье.

### АУДИТЫН ТАЙЛАНГ:

Бэлтгэсэн:  
АУДИТОР

Ч.Чимгээ  
Огноо: 2021.02.18

Анхан шатанд хянасан:  
ХЭЛТСИЙН ДАРГА БӨГӨӨД АУДИТЫН  
МЕНЕЖЕР

А.ЦЭЭНЯМ  
Огноо: 2021.02.18

Хоёр дахь шатанд хянасан:  
ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР

Б.МӨНХБАТ  
Огноо: 2021.02.18

**5. Хавсралт Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт**

Огноо	Аудитын нэр:	Эрдэнэцогт сумын Эрүүл мэндийн төв 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит			Аудитын код:	
2021					БНА-2021/151/СТА-ТШЗ	
Шалгагдсан байгууллагын нэр:		Эрдэнэцогт сумын Эрүүл мэндийн төв			Мянган төгрөг	
№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны		
				Албан тушаал	Овог нэр	
1	2	3	4	5		
1	Ажиллагсдын 522180 төгрөгийн цалинд ноогдох 125323 төгрөгийн шимтгэлийг нийгмийн даатгалд мэдээлээгүй өглөгөөр бүртгэсэн байна.	522,2	Төлбөрийн акт	Эрхлэгч, нягтлан бодогч	С.Батням С.Байгалмаа	
2	Тусгай зориулалттай бараа материал дансанд 20035,5 мянган төгрөгийн, аж ахуйн материал дансанд 7397,9 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө бүртгэгдээд 3-7 жил болсон байна. Хөрөнгүүдийг цаашид ашиглах жилээр ангилахад 17929,2 мянган төгрөгийн эмнэлгийн зориулалттай тоног төхөөрөмжийн элэгдлийн хугацаа дууссан, 9504,2 мянган төгрөгийн 1-8 жилийн дараа элэгдлийн хугацаа дуусах тавилга, эд хогшил бүртгэгдсэн байна.	9504,2	Албан шаардлага өгөх	Эрхлэгч, нягтлан бодогч	С.Батням С.Байгалмаа	
3	Тайлант хугацааны санхүүгийн тайлангаар нийт 15569,4 мянган төгрөгийн өглөгтэй байгаа Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх." заалтыг зөрчсөн.	0	Зөвлөмж өгөх	Эрхлэгч, нягтлан бодогч	С.Батням С.Байгалмаа	
<b>ДҮН</b>		<b>10026,4</b>				

---oOo---